



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тонхил сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/126/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Аудитор:	П. Ганцолмон
	Утас: 70157405	Цахим хаяг: ulistaivanaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

124

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилчдад үр дүнгийн урамшууллыг тушаалаас зөрүүтэй олгосон, нийгмийн даатгалд цалинг дутуу тайлагнасан, татварын тодорхойлолтоор өглөг, авлага зөрүүтэй, шатахууныг бараа материалд орлого аваагүй шууд зардлаар тайлагнасан зэрэг материаллаг 16.7 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07022349

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Албан шаардлага.....	12
4.4 Зөвлөмж	13
4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,221,925.00	36,076,955.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,221,925.00	36,076,955.00
35100	Түүхий эд материал	298,500.00	148,000.00
35110	Тусгай зориулалттай материал	28,000.00	28,000.00
35130	Эм боох материал	270,500.00	120,000.00
35400	Хангамжийн материал	29,923,425.00	35,928,955.00
35410	Бичиг хэргийн материал	1,366,035.00	1,294,035.00
35420	Аж ахуйн материал	19,496,550.00	20,246,550.00
35440	Түлш, шатах тослох материал	8,430,000.00	10,880,000.00
35460	Хүнсний материал	596,030.00	3,473,560.00
35470	Бусад хангамжийн материал	34,810.00	34,810.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	405,024,227.86	388,154,431.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	405,024,227.86	388,154,431.79
39200	Биет хөрөнгө	396,727,477.86	379,932,681.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	380,371,931.91	380,371,931.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,531,818.80	-30,010,448.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	49,311,451.25	50,811,451.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,223,911.39	-40,251,921.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,849,124.00	47,079,124.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,610,701.01	-29,628,858.13
39217	Ном	1,561,401.90	1,561,401.90
39300	Биет бус хөрөнгө	8,296,750.00	8,221,750.00
39301	Програм хангамж	566,200.00	566,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-397,450.00	-472,450.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,128,000.00	8,128,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	435,246,152.86	424,231,386.79
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	435,246,152.86	424,231,386.79
51	Засгийн газрын хувь оролцоо	435,246,152.86	424,231,386.79
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,010,165.40	39,010,165.40
51200	Хуримтлагдсан үр дүн	362,919,600.21	351,904,834.14
51210	Өмнөх үеийн үр дүн	383,224,512.21	362,919,600.21
51220	Тайлант үеийн үр дүн	-20,304,912.00	-11,014,766.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,316,387.25	33,316,387.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	435,246,152.86	424,231,386.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	315,504,572.00	295,290,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,385,800.00	1,730,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,385,800.00	230,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,385,800.00	230,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,385,800.00	230,000.00
122	Тусламжийн орлого	0	1,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0	1,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,118,772.00	293,560,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	285,981,000.00	268,189,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,981,000.00	268,189,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,347,372.00	80,000.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,287,372.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	80,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,790,400.00	25,290,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,790,400.00	25,290,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	335,809,484.00	306,305,066.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,809,484.00	306,305,066.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,476,939.79	287,944,138.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,169,113.57	202,622,373.00
210101	Үндсэн цалин	169,564,864.85	171,581,416.00
210104	Урамшуулал	16,573,220.92	15,963,089.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,031,027.80	15,077,868.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,059,249.22	27,542,660.25
210201	Тэтгэврийн даатгал	19,727,475.22	19,374,297.24
210202	Тэтгэмжийн даатгал	169,598.00	2,027,378.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,702,317.00	1,637,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,222.00	409,359.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,054,637.00	4,094,091.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,082,185.00	15,854,598.86
210301	Гэрэл, цахилгаан	1,262,185.00	1,524,598.86
210302	Түлш, халаалт	11,820,000.00	14,330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,992,466.80	4,585,200.00
210401	Бичиг хэрэг	830,750.00	643,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,236,000.00	2,788,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	29,700.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	59,600.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,000.00	1,073,500.00
210408	Бараа материал акталсны зардал	2,830,116.80	0
2105	Нормативт зардал	13,966,360.00	11,854,010.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000.00	894,250.00
210502	Хоол, хүнс	13,660,360.00	10,659,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,263,000.00	5,160,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	263,500.00	160,000.00
210604	Урсгал засвар	2,999,500.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	196,000.00	0
210702	Дотоод албан томилолт	196,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	944,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	296,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,204,565.20	19,380,796.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360,000.00	781,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,844,565.20	18,599,796.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,332,544.21	18,360,927.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,037,872.00	1,496,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,372.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,500.00	1,496,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,878,715.00	2,065,801.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,878,715.00	1,985,801.14
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	80,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,415,957.21	14,799,126.76
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,415,957.21	14,799,126.76
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-20,304,912.00	-11,014,766.07
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-20,304,912.00	-11,014,766.07

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	383,224,512.21	455,551,064.86
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	383,224,512.21	455,551,064.86
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-20,304,912.00	-20,304,912.00
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	362,919,600.21	435,246,152.86
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	362,919,600.21	435,246,152.86
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	362,919,600.21	435,246,152.86
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,014,766.07	-11,014,766.07
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	39,010,165.40	33,316,387.25	351,904,834.14	424,231,386.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	310,118,772.00	293,560,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,118,772.00	293,560,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	285,981,000.00	268,189,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,981,000.00	268,189,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,347,372.00	80,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,287,372.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	80,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,790,400.00	25,290,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,790,400.00	25,290,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,118,772.00	293,560,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,118,772.00	293,560,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,786,227.79	275,199,372.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,169,113.57	202,622,373.00
210101	Үндсэн цалин	169,564,864.85	171,581,416.00
210104	Урамшуулал	16,573,220.92	15,963,089.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,031,027.80	15,077,868.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,059,249.22	27,542,660.24
210201	Тэтгэврийн даатгал	19,727,475.22	19,374,297.24
210202	Тэтгэмжийн даатгал	169,598.00	2,027,378.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,702,317.00	1,637,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,222.00	409,359.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,054,637.00	4,094,091.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,912,185.00	18,304,598.86
210301	Гэрэл, цахилгаан	1,262,185.00	1,524,598.86
210302	Түлш, халаалт	13,650,000.00	16,780,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,143,350.00	4,511,700.00
210401	Бичиг хэрэг	811,750.00	643,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,236,000.00	2,788,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	29,700.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	59,600.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	13,103,330.00	14,581,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,500.00	743,750.00

Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	12,652,830.00	13,537,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,263,000.00	5,233,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	263,500.00	233,500.00
210604	Урсгал засвар	2,999,500.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	196,000.00	0
210702	Дотоод албан томилолт	196,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	944,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	296,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,000.00	1,459,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,000.00	1,459,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,332,544.21	18,360,927.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,037,872.00	1,496,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,372.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,500.00	1,496,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,878,715.00	2,065,801.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,878,715.00	1,985,801.14
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	80,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,415,957.21	14,799,126.76
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,415,957.21	14,799,126.76
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,480,300.00	276,695,372.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,480,300.00	276,695,372.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,960,300.00	275,199,372.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,235,600.00	202,622,373.00
210101	Үндсэн цалин	175,724,600.00	171,581,416.00
210104	Урамшуулал	18,233,000.00	15,963,089.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,278,000.00	15,077,868.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,401,000.00	27,542,660.24
210201	Тэтгэврийн даатгал	23,719,000.00	19,374,297.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,421,000.00	2,027,378.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,936,000.00	1,637,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	484,000.00	409,359.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,841,000.00	4,094,091.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,290,400.00	18,304,598.86
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	1,524,598.86
210302	Түлш, халаалт	16,790,400.00	16,780,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,864,000.00	4,511,700.00
210401	Бичиг хэрэг	700,000.00	643,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,808,000.00	2,788,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	29,700.00
210404	Ном, хэвлэл	10,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00

2105	Нормативт зардал	15,829,900.00	14,581,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	750,000.00	743,750.00
210502	Хоол, хүнс	14,779,900.00	13,537,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,240,000.00	5,233,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	233,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	0
210702	Дотоод албан томилолт	500,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,138,000.00	944,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,000.00	296,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,461,400.00	1,459,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,461,400.00	1,459,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,520,000.00	1,496,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,520,000.00	1,496,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,520,000.00	1,496,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	293,480,300.00	276,695,372.10
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,189,900.00	253,390,773.24
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,189,900.00	253,390,773.24
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,290,400.00	23,304,598.86
320001	Орон нутгийн төсвөөс	25,290,400.00	23,304,598.86

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	80,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сургалтын амжилт чанар, хөгжил төлөвшилтийг сайжруулан хоцрогдолгүй сургах, эрүүл аж төрөх амьдралын зөв хэв маяг, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах зорилго дэвшүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 263.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 306.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тонхил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.5 хувиар буюу 11.0 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36.1 сая төгрөг болж 5.9 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн, түлш, хүнсний материал өссөнтэй холбоотой.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 42.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 0.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 37.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 488.5 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгээгүй, үнэ төлбөргүйгээр 1.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 424.2 сая төгрөг болж 11.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 6.4 хувиар буюу 20.2 сая төгрөгөөр буурсан нь санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 351.9 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 326.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 33.4 сая төгрөгөөр бууруулж, 293.5 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 293.5 сая төгрөгийн төсөв баталснаас 268.2 сая төгрөгийг тусгай

зориулалтын шилжүүлгээс 25.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 268.2 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 25.3 сая төгрөг нийт 293.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 276.7 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 14.8 сая төгрөгийг 2.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 276.7 сая төгрөг буюу 94.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 6.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 5.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 2.0 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.4 сая төгрөгөөр, норматив зардлыг 1.2 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 0.08 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж зарцуулаагүй татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 38 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12.8 сая төгрөгийн 2

зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг мэдээлээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзэх
2. Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
3. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй

4.2 Төлбөрийн акт

Ажилчдад олгох үр дүнгийн урамшууллыг даргын тушаалаар олгох дүнгээс 58.7 мянган төгрөгийг илүү, 295.0 мянган төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т заасан мөнгөн урамшууллыг олгоход энэ журмыг мөрдөнө", 1.2.1-т "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн

- бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Татварын тодорхойлолтоор 3.7 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
 - Нийгмийн даатгалд ажилчдын цалингаас 8.7 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, 16.1-т "Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын санд шилжүүлнэ." гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
 - Тайлант хугацаанд бэлтгэсэн 2.8 мянган төгрөгийн шатахууныг бараа материалд орлого авч зарлагадаагүй шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"; гэж заасныг зөрчиж, оришин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
 - Гэрэл цахилгаан, шуудан холбоо гэх мэт 1.6 сая төгрөгийн зардлыг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэж заасныг зөрчиж, оришин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 38 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12.8 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг мэдээлээгүй.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах
- 1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тонхил сумын хүүхдийн цэцэрлэг	7	16.7	0	0	1	0.3	5	16.4	1	0